

ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОХ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

2022 он 08 сар 09 өдөр Дугаар 01 Говьсүмбэр аймаг Баянтал сум

Энэхүү ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газраас хоршоог дэмжих зорилтын хүрээнд баталсан төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Хоршооны тухай хуулийн 4.3 дугаар зүйлийн 4.3.1 дэх заалт, "Төсөл сонгон шалгаруулах хороо"-ны 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 01 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн, Монгол улсын иргэний хуулийн 24 дүгээр бүлгийн 281-285 дугаар зүйлүүд, Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын холбогдох зүйл, заалтууд, зээлдэгчийн бичгээр гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн,

Нэг талаас Нэг талаас Хоршоог хөгжүүлэх сан, төлөөлж Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг дарга Ганбат овогтой Анхбаяр /, /цаашид "Зээлдүүлэгч" гэх/,

Нөгөө талаас Зээлдэгч "Орцог-Элгэн" хоршоо /р/д:4615042 үбд:000229443/-ийг төлөөлж дарга Баяжих урчин овогт Намжилын Ганчням /р/д:3Ю81031005/, Хамтран үүрэг гүйцэтгэгч болох Баяжих урчин овогт Намжилын Ганхуяг /р/д: 3Ю74010734 / цаашид /"Зээлдэгч" гэх, гэрээнд оролцогчдыг хамтад нь "талууд" гэх/ нар харилцан тохиролцож дараах нөхцөлөөр гэрээ байгуулав.

**Нэг. Гэрээний ерөнхий зүйл**

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын Иргэний хууль, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ дэмжих тухай хууль, Хоршооны тухай хуульд нийцүүлэн Экспортыг дэмжих, импортыг орлох, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор **Хоршоог хөгжүүлэх сангаар** дамжуулан хоршоонд хөнгөлөлтэй нөхцөл бүхий зээлийг олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, зээлийн зарцуулалтад хяналт тавих, зээлийг буцаан төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Нэг талаас Зээлдэгч нь зээлийг энэхүү Гэрээнд заасан хэмжээ, нөхцөлөөр авах, нөгөө талаас нь гэрээнд заасан нөхцөлөөр зээл олгохоор харилцан хүсэл сонирхлоо илэрхийлсний үндсэн дээр Талууд доорх нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцов.

**Хоёр. Тодорхойлолт, тайлбарууд**

2.1. Энэхүү гэрээнд заасан нар томъёонгуудыг дараах утгаар ойлгоно:  
2.1.1 Хоршоог хөгжүүлэх сан - энэхүү гэрээгээр зээл олгож байгаа Зээлдүүлэгч буюу Хоршооны асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаг;  
2.1.2 Төсөл сонгон шалгаруулах хороо - гэж Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журамд заасан хоршоог;  
2.1.3 Зээлдэгч -энэхүү зээлийн гэрээгээр түүнд заасан нөхцөл болзолтойгоор зээл авч байгаа хуулийн этгээдийг буюу хоршоог;

2.1.4 Зээл – Хорооноос сонгон шалгаруулсан Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хоршоонд энэ гэрээнд заасан нөхцөл журмын дагуу зээлдүүлж буй мөнгөн хөрөнгийг;  
2.1.5 Үндсэн хүү – гэж зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцоо зээлдэгчийн хариу төлбөр буюу зээлийн үнийг /Цаашид "хүү" гэх/;  
2.1.6 Алданги-Алданги гэдэг нь хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосноосгүй.

2.1.7 Барцаа хөрөнгө- Зээлдэгчээс зээлээ буцааж төлөх баталгаа болж Хоршоог хөгжүүлэх санд барцаалж байгаа барцааны гэрээнд заасан үл хөдлөх хөрөнгийг;

